

Үндэстний соёлын нөлөөн доорх бэлгийн үзэл баримтлал: Хан үндэстэн ба Өвөр Монголчуудыг харьцуулах нь

Тунгалаг^{1, *}

Товч агуулга: Уг өгүүлэлд бэлгийн үзэл баримтлалд туссан уламжлалт соёлын нөлөөллийг Хятадын хан үндэстэн болон Өвөр Монголчуудын жишээгээр харьцуулан соёлын орчин дахь бэлгийн үзэл баримтлалын ялгарааг тодруулахыг зорьсон юм. БНХАУ-ын судлаачид хан үндэстний бэлгийн үзэл баримтлалын талаар эх бичгийн судалгаанаас эхлээд нийгмийн ухааны судалгаа хүртэл өргөн хүрээнд судалсан түүхтэй. Гэвч уг судалгаанд Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын талаарх судалгааны ажил маш цөөн бөгөөд тодруулбал, зөвхөн уран зохиолын дүрийн судалгаагаар дамжуулан энэхүү үзэл баримтлалын талаар дам авч үзэж байсан оролдлого байна. Бид уг судалгаандаа “уламжлалт соёл” нь бэлгийн үзэл баримтлалд нөлөөлөх төдийгүй цаг хугацааны явцад уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь орчин цагийнхаа үзэл баримтлалтай сүлэлдэж, бусад соёлын бэлгийн үзэл баримтлалд ч нөлөөлдөг гэх санаагаа дэвшүүлээ. Үүний тулд өмнө хийгдсэн судалгаа, сурвалж бичгийн эх баримт, Хятадын Хан үндэстэн болон Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын тодорхой жишээ, бодит тохиолдолд / кэйс/ задлан шинжилгээ хийж үзлээ.

Түлхүүр үг: Үндэстний соёлын нөлөө, бэлгийн үзэл баримтлал, Хан үндэстэн, Өвөр Монголчууд

Удиртгал

Соёл нь бэлгийн үзэл баримтлалын үүсэл, хувьсалд шууд нөлөөтэй. Бэлгийн үзэл баримтлал нь бодгаль биеийн бэлгийн чиг баримжаа болон үйл ажиллагааны хэлбэрийг бүрэлдүүлэх төдийгүй эргээд тухайн нийгмийн бүтэц болон соёлын хөгжилтөд нөлөөлдөг. Тиймээс уламжлалт соёл болон орчин цагийн огтлолцлын энэ цаг үед соёл бэлгийн үзэл баримтлалд хэрхэн буйг ойлгох нь маш чухал юм.

Хятадын уламжлалт бэлгийн үзэл баримтлалын судалгааны хувьд, судлаачид хятадын эртний гүн ухаан, эртний сурвалж бичгүүдэд бэлгийн үзэл баримтлал хэрхэн тусгагдаж байгаад анхаарлаа голлон хандуулдаг. Жишээлбэл, “Ёслолт ном”, “Шүлэглэлт ном”, “Жүү и бичиг” дэх Күнзийн сургаалтны бэлгийн үзэл баримтлал, “Лао зи” дэх Даогийн сургаалтны бэлгийн үзэл баримтлал зэрэг судалгаа бий. Тэд Күнзийн сургаалтны эдгээр сурвалжуудаас “эрэгтэй эмэгтэй хүйсийн ялгаа”, “эрэгтэй-эрхэм, эмэгтэй-доорд”, “эрэгтэй-гадна, эмэгтэй-гэрт” зэрэг хятадын уламжлалт бэлгийн үзэл баримтлалын “соёлын” үүдлийг эрэлхийлж, “Күнзийн сургаалтнууд жендэрийн үүрэг, гэр бүлийн дэглэмийг бүрдүүлэхийг илүүд үздэг” гэсэн санааг голлон дэвшүүлсэн. Түүнчлэн, Даогийн сургаалтны бэлгийн үзэл баримтлал нь жендэрийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийг хүндэтгэсэн үзэл баримтлалтай

хэмээн үзсэн байна. Мөн эдгээр судалгаанд Даогийн сургаалтны бэлгийн үзэл баримтлал болон одоогийн феминизмийн адил төстэй тал олон байгааг, жендэрийн тэгш эрхийг чухалчилснаараа Күнзийн сургаалтны бэлгийн үзэл баримтлалтай зөрчилдөж байдаг гэсэн санааг онцлон дэвшүүлжээ. Эдгээр санааг тоймлон авч үзвэл, Күнзийн сургаалтны бэлгийн үзэл баримтлалын талаар ихэнх судлаачид, Күнзийн сургаалтнууд жендэрийн үүргийг хэт чухалчлан хүйсийн тэгш биш байдлыг бий болгосон хэмээн шүүмжилсэн санааг дэвшүүлсэн байхад зарим судлаачид эсрэгээр жендэрийн үүргийг чухалчилсан нь нийгмийн хөгжилтөд ашиг тусаа үзүүлсэн гэсэн санааг бас дэвшүүлсэн байдаг.

Даогийн сургаалтны бэлгийн үзэл баримтлалын хувьд хятадын уламжлалт жендэрийн эрх тэгш үзлийн үндэс сурвалж, хятадын уламжлалт соёлд эрэгтэй эмэгтэй хүйс “эрх тэгш” байдаг гэсэн үзэл баримтлал давамгайлсан байна.

Хятадын бэлгийн үзэл баримтлалын сэдэвт сурвалж бичгийн судалгаанаас гадна хууль эрх зүй, хэвлэл мэдээлэл, уран зохиол, кино урлагт туссан бэлгийн үзэл баримтлал, хот хөдөөгийн бэлгийн үзэл баримтлалын ялгараа, өөрчлөлт зэрэг олон асуудлыг хамруулж болно. Эдгээр судалгааны дундаас оюутнууд, тэр дундаа эмэгтэй оюутнуудын бэлгийн үзэл баримтлалын судалгаа онцгой анхаарал татаж байна. Эдгээр судалгаа нь ихэвчлэн тоон судалгааны аргад тулгуурласан бөгөөд судлаачид уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь орчин үеийн оюутнуудын бэлгийн үзэл баримтлалд ихээхэн нөлөөлсөн гэсэн

¹ МУИС, Антропологи, археологийн тэнхим, докторант

* Холбоо барих зохиогч: 22D1NUM0474@stud.num.edu.mn

дүгнэлт дэвшүүлжээ. Тодруулбал, судлаачид эмэгтэй оюутнууд нийгэм, гэр бүл дэх эрэгтэй эмэгтэйн жендэрийн үүрэгт уламжлалт үзэл баримтлалтай, тэрхүү уламжлалт үзэл баримтлал нь эмэгтэй оюутны ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлж, тэдний хувь хүний хөгжилд саад тогтор болсон гэжээ. Ингэснээ эмэгтэй оюутнууд “бэлгийн “зөв” үзэл баримтлал”-тай байхыг сурталчилж, бодгаль биеийн чадвараа дээшлүүлэх хэрэгтэй гэдэг дүгнэлтийг өгсөн байна. Үүнээс гадна, хан үндэстний бэлгийн үзэл баримтлал бусад үндэстний цөөнхийн бэлгийн үзэл баримтлалд нөлөөлсөн тухай судалгаа цөөн боловч байна. Ийм нэг судалгаанд Манж үндэстэн боомтод /Цагаан хэрмийн дотоодод/ орсноор хан үндэстэнтэй уусалцаж Күнзийн үзэл санааны нөлөөгөөр “харьцангуй хөгжилтэй” бэлгийн үзэл баримтлалтай болж, эергээр нөлөөлөхцөн гэдэг санааг дэвшүүлсэн байдаг.

Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын соёлын нөлөөний судалгааны хувьд маш цөөн. Судлаачид дээр дурдсанчлан уран зохиолд бэлгийн үзэл баримтлал хэрхэн тусгагдаж байгаад гол анхаарлаа тавьсан байна. Тэд голчлон уран зохиол дахь эмэгтэйчүүдийн дүрд дүн шинжилгээ хийж, эдгээр зохиол бүтээл нь уламжлалт бэлгийн үзэл баримтлалыг ашиглан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн дүрийг бүтээж байгаа гэж санаагаа дэвшүүлжээ. Мөн судлаачид эрэгтэй зохиолчид зохиол бүтээлдээ эмэгтэйчүүдийн дүрийг сул дорой талаас нь, эрэгтэйчүүдийн дүрийг хүчирхэг талаас нь дүрсэлснээрээ жендэрийн эрх тэгш биш байдлыг номлож байна гэж үзжээ. Хэл шинжлэлийн талаас Монголчуудын хэлц үг дэх Монголчуудын бэлгийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж, хэлц үгэнд тусгагдаж байгаа бэлгийн үзэл баримтлал бол соёлын нөлөөлөл мөн гэсэн санааг дэвшүүлжээ. Үүнээс гадна, эртний Монгол эмэгтэйчүүдийн түүхэн байр суурийн талаар судалгаа хийсэн байдаг. Үүнд, Их Монгол Улсын үе, Юань улсын үеийн дээд давхаргын эмэгтэйчүүдийн байр суурь бусад суурин үндэстний эмэгтэйчүүдийн байр сууриас өндөр байдаг гэдэг санаагаа тодруулсан байна. Гэсэн хэдий ч, эртний Монгол эмэгтэйчүүдийн байр суурийг судлахдаа дээд давхаргатны эмэгтэйчүүдийн байр суурь өндөр байгааг товойлгож, харин эгэл ард эмэгтэйчүүдийн байр суурийн тухайд анхаарлаа хандуулаагүй. Түүнчлэн, уламжлалт зан заншил дахь бэлгийн үзэл баримтлалыг судлахдаа эртний Монгол эмэгтэйчүүдийн жишээгээр Монголд эмэгтэйчүүдийн байр суурь өндөр байдаг гэдгийг гэрчлэх нь илүү байдаг. Өөр нэг тэмдэглэх ёстой зүйл бол, Монголын уламжлалт зан үйл дэх эмэгтэйчүүдийн байр суурийг өгүүлэхдээ судлаачид өөрсдөө уламжлалт бэлгийн үзэл баримтлалыг баримталж тайлбарласан байдаг. Энэ судалгаанууд нь хэдийгээр Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлалыг ойлгоход анхны алхмын

мэдээ занги болсон боловч Өвөр Монголчуудын одоогийн бэлгийн үзэл баримтлалд уламжлалт соёлын нөлөө, бусад үндэстний соёлын нөлөөний тухай социологи, антропологийн судалгаа одоо ч маш цөөн байна.

Тийм учраас бид энэ өгүүлэлдээ доорх санааг дэвшүүллээ. Хятадын уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь Күнзийн сургаалд (эрэгтэй эмэгтэй адилгүй) тулгуурлаж ирсэн бөгөөд энэ нь жендэрийн үүргийн ялгааг чухалчилдаг, одоогийн хан үндэстний бэлгийн үзэл баримтлалд гол, гүн нөлөө үзүүлсэн. Үүнтэй харьцуулбал, Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын хувьд нүүдлийн малчин нийгмийн шаардлагаар эрт дээр үеэс өнөөг хүртэл хүйсийн тэнцвэр харьцангуй тэгш байдалтай байсаар ирсэн ч, зарим зан үйл, заншил болон хорио цээрийн ёсонд (эрэгтэй эмэгтэй адилгүй) бас ч жендэрийн тэгш бус байдал ямар нэгэн хэмжээгээр илэрдэг байна. Хан үндэстэн болон Монгол үндэстэн нь өөр өөр соёл иргэншилтэйгээс өөр өөр бэлгийн үзэл баримтлалтай байсан ч бэлгийн үзэл баримтлал нь бүр жендэрийн үүрэг, хөдөлмөрийн хуваарийг чухалчилдгаараа адилхан байна. Ялгараатай тал нь, Хан үндэстний уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь өдөр тутмын амьдрал, ёс суртахуунаар (ил чанартай) илэрдэг бол Монголчуудын бэлгийн үзэл баримтлал нь зан заншил болон хорио цээрт (далд чанартай) далдлагдсан байдаг.

Уламжлалт соёл дахь бэлгийн үзэл баримтлал

Энэ хэсэгтээ Хятадын Хан үндэстэн болон Монгол үндэстний бэлгийн үзэл баримтлалыг нөлөөлсөн түүхийг товчлон танилцуулах бөгөөд уламжлалт соёлд нь бэлгийн үзэл баримтлал хэрхэн тусаж байгаа талаар өгүүлэх болно.

Хан үндэстний бэлгийн үзэл баримтлал

Эртний Хятадын гүн ухаан нь Хан үндэстний нийгмийн соёл, ёс суртахуун, нийгмийн тогтолцоо, үнэт зүйлд гүн гүнзгий нөлөө үзүүлсээр ирсэн. Күнзийн бэлгийн талаарх үндсэн үзэл баримтлал бол “эрэгтэй, эмэгтэй ялгаатай”-д байдаг. Энэ ялгаа нь эмэгтэйчүүдэд зориулсан хоёр дэглэмийг бий болгосон, Нэг нь, “эрэгтэй нь тарианы ажилд, эмэгтэйчүүд нь нэхмэлийн ажилд”, “эрэгтэй нь гаднах ажилд, эмэгтэй нь гэрийн ажилд” гэдэг нийгмийн ажлын хуваарьт, нөгөө нь, “нэг нөхөр нэг эхнэр, олон татвар эхнэр” гэдэг ураг гэр бүлийн хүрээнд тодордог. Күнзийн суртгаалтан бас арга билиг, тэнгэр газар зэрэг байгалийн үзэгдлийг ашиглан “эрэгтэй эмэгтэй ялгаатай” гэдэг үзлийнхээ үндэс суурь болгож, нэг талаар арга билиг харилцан нөхвөрлөдөг тухай ярьж,

нөгөө талаар нь арга (эрэгтэй) эрхэм дээд, билиг(эмэгтэй) эгэл доорд гэдэг санааг онцлон тэмдэглэжээ (方旭东 2020). Күнзийн иймэрхүү бэлгийн үзэл баримтлалын нөлөөн дор эмэгтэйчүүдийн боловсрол, зан байдлын тухай маш олон ном бичигджээ. Бан жуу-гийн “Эмэгтэйн цээрлэл”, Мин гүрний үеийн өршөөл элбэрэлт Вен хатны зохиосон “Дотоод сургаал”, Тан гүрний үеийн Сүн Руо зао-ийн бичсэн “Эмэгтэйн сургаал бичиг”, “Эмэгтэйн үлгэр дуурайлын тэмдэглэл” зэрэг нь “Эмэгтэйн дөрвөн ном” болж алдаршин БНХАУ-ын эхэн үе, түүнээс өмнөх үеийн ном бичиг сурсан эмэгтэйчүүдийн унших ёстой анхны номууд байжээ. Үүнд хамгийн алдартай нь Хан улсын Лиу шиянгийн “Охидын шастир”¹, Бан жуу-гийн “Эмэгтэйн цээрлэл”² зэрэг номыг дурдах ёстой. Гэхдээ 1949 онд БНХАУ байгуулагдснаас хойш нам засгаас “эрэгтэй эмэгтэй эрх тэгш” байхыг ихээр сурталчилж, онцгойлон “Соёлын их хувьсгал”-ын үед эмэгтэйчүүдийг чөлөөлөх хөдөлгөөн оргилдоо тулжээ. Ингээд “эмэгтэйчүүд бол төрийн хагас тулгуур”, “Төмөр хүүхнүүд” гэдэг уриа олширч, суртал ухуулгын зурагт хуудсанд эмэгтэй жолооч, эмэгтэй эмч, эмэгтэй байлдагч зэргийн дүрийг сурталчлах болжээ (方旭东 2020). Хэдийгээр төрийн оролцоо, гадаад харилцаа, соёлын солилцоо зэргээс шалтгаалж ингэж Хан үндэстний бэлгийн үзэл баримтлалд хувьсал гарч байгаа боловч хэдэн мянганы турш үргэлжилсэн Күнзийн үзлийн нөлөө орчин үеийн бэлгийн үзэл баримтлалд одоо ч гэсэн тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байна. Модернизацийн онол нь Хятадын уламжлалт бэлгийн үзэл баримтлалын байдлаас жендэрийн эрх тэгш байдлын загвар болж өөрчлөгдөж байна гэж үздэг хэдий ч 2000 ба 2010 оны эмэгтэйчүүдийн нийгмийн байдлын тухай тоон судалгааны дүнгээс харахад, хөдөлмөрийн хуваарилалт, ажил мэргэжлийн хөгжил, гэрлэлт ба гэр бүл, төрөлт, хүүхдийн боловсролын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлын ойлголт суларч, уламжлалт үзэл баримтлал хувирмал хэлбэрээр нийгэмд оршиж байна. Зах зээлийн чөлөөтэй өрсөлдөөн нь уламжлалт жендэрийн үүрэгт суурилснаас болж эмэгтэйчүүд зах зээлд шигшигдэж, доод байранд орсон, цаашлан эмэгтэйчүүдийг бараа болгож, уламжлалт соёлоор шалтаг болгож эмэгтэйчүүдийн хүн чанар, эмэгтэйчүүдийн эрхэд

хохирол учруулах болжээ (顾辉 2013).

Ерөнхийлбөл, Күнзийн сургаалын бэлгийн үзэл баримтлал нь Хан үндэстний гэр бүлийн бүтэц, нийгмийн үүрэг, ёс суртахууны хэм хэмжээ, боловсролд голчлон нөлөөлдөг. Күнзийн сургаалтны сонгодог бүтээл “Ёслол ном”-д дурдсан “эрэгтэй, эмэгтэй ялгах” зарчимд “эрэгтэйчүүд нийгмийн хүрээнд, эмэгтэйчүүд гэр бүлийн хүрээнд” гэж тодорхойлсон. Ингэснээр эрэгтэйчүүдийн давамгайлсан, эмэгтэйчүүдийн дагалдагч гэсэн уламжлалт гэр бүлийн загварыг бий болгосон. “Гурван үндсэн зарчим, таван байнгын ёс”³-ийн “эхнэр нь нөхөртөө “ нь нөхрийн эхнэрээ захирах эрхийг тодорхойлж, гэр бүл, нийгэмд эрэгтэйчүүдийн давамгайлсан байр суурийг бэхжүүлсэн бол “таван байнгын дүрэм” нь нийгмийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийг тодорхой ялгаж, дэг журмыг баталгаажуулсан. “Күнзийн сургаал бичиг”, “Мэнзи бичиг” зэрэг сонгодог бүтээлүүд нь эмэгтэйчүүдээс даруу зөөлөн, ариун цагаан зан чанарыг шаарддаг. Энэ нь жендэрийн үүрэг хүлээлт, үнэлгээний стандартыг нийгэмд тогтоож өгдөг. Уламжлалт боловсролын тогтолцоонд эрэгтэйчүүд албан ёсны боловсрол эзэмшиж, эмэгтэйчүүд голчлон гэр бүлийн боловсрол эзэмшдэг байсан нь жендэрийн үүрэг хуваарилалтад бэхжиж, эрэгтэйчүүд олон нийтийн салбарт давамгайлсан, эмэгтэйчүүд гэр бүлээр хязгаарлагдсан байдаг ажээ. Күнзийн сургаалын бэлгийн үзэл баримтлал гэрлэлтийн болон гэр бүлийн харилцааны хэм хэмжээ нь хүйсийн үзэл баримтлалд гүнзгий нөлөөлсөн. Энэхүү бэлгийн үзэл баримтлал нь одоо ажил олголт, гэр бүлийн хөдөлмөрийн хуваарилалд илүү тусгагдаж, газар орны хувьд голдуу эдийн засгийн хөгжилтөөр хоцрогдсон хөдөө тосгонд илэрхий харагддаг.

Хятадын түүхэнд, Күнзийн сургаал өргөн дэлгэр тарахаас өмнө Хятадын бэлгийн үзэл баримтлал нь харьцангуй чөлөөтэй байсан бөгөөд Даосизмийн бэлгийн үзэл баримтлал нь жендэрийн тэгш байдлыг дэмжиж байсан. Гэсэн хэдий ч, феодалын нийгмийн эцэгчлэлийн дэглэм дор Күнзийн сургаалын бэлгийн үзэл баримтлал нь засаглалд илүү тохиромжтой болж “эрэгтэй, эмэгтэй-ялгаатай” ба жендэрийн үүргийн хуваарийг онцлон үздэг нь феодалын нийгмийн дэг журмыг сахих болон гэр бүлийн бүтцийг хадгалахад нийцэж байсан тул хүлээн зөвшөөрөгдөж, уламжлагдаж ирсэн юм. Өнөө дэлхий дахинаараа жендэрийн тэгш байдлыг дэмжиж байгаа цагт энэ Даогийн бэлгийн үзэл баримтлал нь Хятадын судлаачдын хан үндэстэн эртнээсээ жендэрийн эрх тэгш байдлыг чухалд үздэг гэдэг үзлийн нотолгоо

¹Баруун Хан улсын үед бичигдсэн, долоон боть ном. Тодруулвал: “Эгээгийн ёст шастир”, “Мэргэдийн шастир”, “Өршөөл журмын шастир”, “Ариун журмын шастир”, “Цэгц журмын шастир”, “Гэгээн ухаантны шастир”, “Нүгэлт эмэгтэйн шастир”. Өмнө зургаа нь ухаалаг, ариун цэгц зэрэг зан ариунаараа гэр бүл, улс гүрний хөгжин мандалтад эерэг нөлөө болсон эмэгтэйчүүдийн үйл явдлыг жишээ болгож бичсэн. “Нүгэлт эмэгтэйн шастир” нь эмэгтэйчүүдийн ёс суртахууныг зөрчсөнөөс болж гэр бүл, улс гүрэндээ сөрөг нөлөө болсон үйл явдлыг жишээ болгож бичсэн.

²Долоон бүлэгтэй, гол нь эмэгтэйчүүдийн боловсролын гурван асуудлыг өгүүлсэн. Нэг нь, эмэгтэйчүүд бие засах ёсон, хоёр нь, эхнэр нөхөр эе эвтэй харилцах ёсон, гурав нь, хадмынхантайгаа эе эвтэй харилцах ёсон.

³“Гурван үндсэн зарчим”: Түшмэл нь эзэндээ, хүү нь эцэгтээ, эхнэр нь нөхөртөө захирагдах. “Таван байнгын ёс”: Энэрэл, шударга ёс, ёс зүй, мэргэн ухаан, итгэл

болжээ. Гэсэн хэдий ч, Хан үндэстний бэлгийн үзэл баримтлалыг хамгаас илэрхий нөлөөлсөн нь Күнзийн сургаалтны бэлгийн үзэл баримтлал гэдгийг Хятадын түүхэн баримт бичиг, гэр бүлийн бүтэц, нийгмийн соёл, боловсролын тогтолцоо зэрэг олон зүйл гэрчилж байгаа юм.

Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлал

Өвөр Монголчуудын хувьд бэлгийн үзэл баримтлалынх нь онцлог бол эрх чөлөөтэй, эрэгтэй эмэгтэй харьцангуй эрх тэгш байдаг. Үүнийг гол нөлөөлж байгаа зүйл нь бол уламжлалт нүүдэл соёл болон шашин юм. Хүйсээс үл хамааран бага наснаасаа эхлэн бүх Монголчууд зөвхөн өөрийгөө бие даасан байхыг дэмждэг төдийгүй, малын селекцийг удирдах, тухайлбал, мал хөнгөлөх, мал сүргийг хүйсээр нь ангилах, сүргийн бүтцийн тоог тогтоох, эцэг мал тавих зэрэг мэдлэгт гаргууд байсан. Түүнчлэн, Барууны орнуудад хүний “хувийн орон зай” гэж тодорхойлдог зүйл нь Монголын амьдралын хэв маягт огт хамааралгүй байсан; жижиг гэрт олуул хамт амьдардаг тул гэрт болж буй бүхий л үйл ажиллагаа, түүний дотор бэлгийн харилцааны үйл ч ил харагдаж, сонсогддог байв (Baasanjav 2013). Тийм мөртөө Монголын эртний хуульд “хүний эмд орвоос” хууль зөрчиж ял шийтгэл оноодог боловч ганц бие эмэгтэй буюу охидтой бэлгийн харилцаанд ороход яах тухай тодорхойгүй үлдээсэн. Энэ нь гэрлэсэн эмэгтэйчүүд бэлгийн үйлийн хувьд нөхөртөө харьяалагдах ба охиных нь бэлгийн эрх чөлөө нь өөрт нь хамаардаг, харин эцэгт нь харьяалагддаггүй байжээ. Тийм учраас Монголчуудын уламжлалт соёлд охидын онгон байдлын талаар шууд холбоотой хууль, зүйр үг, соёл суртахууны заалт байхгүй (Baasanjav 2013). Тийм учраас Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын иймэрхүү эрх чөлөөтэй байдал нь Монголчуудын жендэрийн эрх тэгш байдлыг нөхцөлдүүлж өгсөн учир эмэгтэйчүүд ч гэсэн өөрийгөө илэрхийлж чаддагаараа хан үндэстний эмэгтэйчүүд эцэгчлэлийн эрхэн доор бүрэн эрхшээгдэж байсантай адилгүй юм.

Монголчуудын уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь эртний Монголын дээд давхаргын эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засгийн оролцоо болон Монголчуудын уламжлалт гэр бүлийн хүмүүжилд тод илэрдэг. Энэ нь Монголчуудын бэлгийн үзэл баримтлалын жендэрийн эрх тэгш үзэл, эмэгтэйчүүдийг хүндэтгэх үзлийнх нь хамгийн сайн гэрч юм. Монголчуудын тухай түүхэн баримтаас харахад, эртний Монгол эмэгтэйчүүд улс төрд их оролцдог байсан. Есүгэй баатар насан эцэслэж, Монгол аймгийн хүчин суларч доройтох үед Өгөлүн хатан хүнд хэцүү байдлыг даван туулж, үр хүүхдээ хүний зэрэгт хүргэж, сүүлээр нь Тэмүжин олон аймгийг дайлан дагуулж хаант улсаа байгуулжээ.

Өгэдэй хааны Наймалжин хатан 1241-1246 он хүртэл 5 жил, 1248 оноос Гүюг хааны хатан Огул Хаймиш 2 жил төр барьснаас гадна 1294 онд Хубилай хаан нас нөгчихөд Хөхчин хатан, 1307 онд Өлзийт төмөр хаан нас барахад Булган хатан нар тус тус төрийн хэргийг хөтлөн их хурилдайг хуралдуулж дараачийн хааныг сонгуулжээ. 13 дугаар зууны дөчөөд онд урьд хожид хоёр эмэгтэй Монгол улсын төрийг барьсан, энэ нь түүхэнд маш ховор тохиолдол юм (陈高华 2018). Үүнээс гадна, уламжлалт нүүдэл малжлын амьдралын хэв маяг нь нийгмийн үйлдвэрлэлд жендэрийн ялгаагүйгээр оролцохыг шаарддаг. Энэ нь эцэгчлэлийн нийгэмд Монгол эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрхийг нэмэгдүүлж, нийгмийн байр суурийг нь харьцангуй нэмэгдүүлжээ. Монголчуудын нийгэмд охидоо гэрээлүүлэхдээ инж (эд хөрөнгө) өгдөг заншилтай. Энэ нь инжийг охиныхоо хувийн эд хөрөнгө болгож гэрээлүүлж байна гэсэн үг, энэхүү хувийн эд хөрөнгөө өөрөө эзэн мэдэх эрхтэй, зарим тохиолдолд, инжний их багаар гэр бүл дэх байр суурь, эрх мэдэл хир их нь илэрдэг. Эд хөрөнгө болон эрх мэдлийн талаар Монгол эхнэрүүдийн жишээнээс харж болно. Монгол нутагт аялсан гадаадын хүмүүсийн ажигласанаар, Монгол эхнэрүүд гэр бүлдээ үг хэлэх маш их эрхтэй байдаг, гэхдээ гэр бүл дэх эрх мэдэл ямар байсан ч гэсэн нийгмийн хүрээнд мөн л гэрийн эзэн (эрэгтэй) өөрийн гэр бүлээ төлөөлдөг, эд хөрөнгө нь бас түүнд харьяалагддаг (Baasanjav 2013). Монголчуудын ёс суртахуун ба үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд гэр бүлийн хүмүүжил асар их үйлдэлтэй юм. Монголчууд хүүхдийн гэр бүлийн хүмүүжилд аав ээжийн алинг ч дутаж болохгүй гэж үздэг. Үүнд онцгойлон бага насны хүмүүжилд эх хүмүүн хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг. Гэр бүлийн хүмүүжилд эмэгтэй хүмүүний гүйцэтгэдэг үүргээр дамжуулж Монголчууд эх хүмүүнийг хүндэтгэдэг, жендэрийн эрх тэгш байдлыг чухал гэдэг үзэл баримтлалаа тодруулдаг.

Монголчуудын уламжлалт нийгэм жендэрийн хувьд харьцангуй тэгш байдаг нь тэдний түүх, соёл иргэншлээс шалтгаалдаг бол эцэгчлэлийн дэглэмд тохирсон эрэгтэй эмэгтэй хүйсийн ялгаа, жендэрийн үүргийн ялгаа нь тэдний хорио цээр, тахилга тайлга, хэлц үгэнд нь тусгагдаж олон соёлын үзэгдэлд нь шингэсэн байдаг. Монголчуудын “хорио цээр” хэмээх ойлголт нь Полинез хэлний Taboo гэдэг үгтэй төстэй утгатай. Зигмунд Фрейд “Тотем ба хорио цээр” гэдэг бүтээлдээ хорио цээр нь хоёр өөр утгыг илэрхийлдэг, нэг талаар “агуу их”, “ариун дархан”, нөгөө талаар “нууцлаг”, “аюултай”, “ариун биш” гэдэг утгатай байдаг гэжээ (弗洛伊德 2015). Табугаар илэрсэн цээрлэх ёс нь шашны болон ёс суртахууны сахилгатай адилгүй. Тэр нь заавал шашны зан үйлээр биш, харин өөрт нь илэрдэг. Ёс суртахууны сахилгаас ямар ялгаатай гэвэл энэ нь тодорхой, ажиглагдахуйц цээрийн мэдэгдэлгүй,

үүний зэрэгцээ хорио цээрийн ямар ч шалтгаангүй байдаг. Хэдийгээр тэр нь бидэнд ухаалаг биш, бүр ч мохоор сүсэг байдаг ч ноёрхогч буюу засаглагчдын хувьд энэ нь энгийн бөгөөд зүй ёсны гэрэг болдог (弗洛伊德 2015). Монголчууд нутгийн эзэд сахиус, овоонд оршсон сахиусыг шүтдэг тул овоо нь эртнээс аваад Монголчуудын дээдсийн сүнс сүлд тахих талбарын хувьд ариун дархан газар болохын хувьд овооны ариун дархан байхыг хангахын төлөө цээр ёс бүрэлдсэн байдаг. Үүнд эмэгтэй хүний физиологийн ажиллагаанаас нь үндэслэж тодорхой насанд хүрсэн эмэгтэйчүүдийг “ариун бус” хэмээн үзэж овоо тахилга ба овооны дэргэд очуулдаггүй нь тэдгээр олон цээр хорио ёсны нэг бүрэлдүүн болсон нь яриангүй билээ (Гэрэл 2017). Үүнээс Монголчуудын хувьд овоо бол “ариун дархан”, эмэгтэй хүмүүн бол “бузартсан” хэмээх үзэл тодорхой харагдаж байна.

- Энэ жил танайхаар гангийн байдал гайгүй биз?

- Манайхаар ган бас гайгүй.

- Хонгор суманд аймаар гандсан гэсэн, яагаад гандсаныг мэдэх үү?

- Тэдний сумынхан сумын овоогоо жил жил ламаар ном уншуулж тахидаг байсан. Энэ жил харин нэг эмэгтэй бөөгөөр бөөлүүлээд овоо нь бузартаад Хонгорт дахиж бороо ороогүй, аймаар ган болсон гэнэ. Тэр овоо нь эмэгтэй хүн гарч болдоггүй гэж байна шүү (Зохиогчийн хээрийн шинжилгээний тэмдэглэлээс).

Иймэрхүү эмэгтэйчүүд “ариун дархан” орныг “бузартуулдаг” гэдэг ойлголт нь Монголчуудын нийгэмд маш түгээмэл байдаг. “Бөх хүний мөрөн дээр эмэгтэй хүн гараа тавьж болохгүй”, “эрэгтэй хүнээр үнс хогоо асгуулбал эр хүний хийморь хэвтэнэ” гэдэг цээр хорионууд нь эрэгтэй хүний хийморь бол “ариун дархан”, эмэгтэй хүний гар буюу эмэгтэй хүнд хувьдсан ажил нь эрэгтэй хүнийг “бузартуулдаг”, энэ нь олонхдоо “хийморь хэвтэх” гэдгээр илэрдэг. Жишээ нь, эр нөхөр нь архинд орох, ажил үйлс нь бүтэмжгүй болохыг “хийморь нь хэвтсэн” гэж, энэ нь зарим тохиолдолд эмэгтэй хүнтэй холбогдох цээр хориог зөрчсөнөөс болсон гэж үздэг. Зарим зүйл нь маш урт хугацаагаар цээрлэгдэж байдаг ч гэсэн тэдгээр хүмүүс хэзээд учир шалтгааныг нь хайдаггүй мөртөө ямар ч таамаглал дэвшүүлдэггүй. Харин тэд ийм хорио цээрийг зөрчсөн тохиолдолд шийтгэл хүлээнэ гэдэгтэй итгэж, жам ёсны хэрэг мэт үздэг (弗洛伊德 2015). Энэ тухай тусгай ажиглалт хийж ойлгохоос өмнө, иймэрхүү хорио цээр нь уламжлалт гэр бүл, настайчуудын дунд илүү илэрдэг байх гэж боддог байсан бол гэрлэсэн залуу бүсгүй, гэрлэх насны охид ч иймэрхүү үзэл баримтлалыг түгээмэл хүлээн зөвшөөрдөг гэдгийг ажиглаж ойлгосон. Энэ нь уламжлалт бэлгийн үзэл баримтлал одоо хүртэл

Монголчуудын бэлгийн үзэл баримтлалд нөлөөлж байна гэдэг санаагаа улам нотлоход хүргэсэн.

Дүгнэж хэлэхэд, Хан үндэстний бэлгийн үзэл баримтлалд Күнзийн сургаал хамгийн их нөлөөлсөн болохыг бидний ажиглалт судалгаа харуулж байна. Күнзийн сургаал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа, жендэрийн үүргийг онцолж, жендэрийн хэм хэмжээг бүрдүүлдэг. Харин Монголчуудын уламжлалт нүүдэл малжлын соёл нь нийгэм, ёс суртахуун, үнэт зүйл, жендэрийн үзэл баримтлалд нөлөөлдөг. Монголчуудын жендэрийн үзэл баримтлал түүхэнд харьцангуй тэгш, гэр бүл, нийгэмд эмэгтэйчүүд илүү өндөр байр суурь эзэлж байдаг. Гэсэн хэдий ч уламжлалт зан заншилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааны тухай ойлголтыг тусгасан жендэрийн тэгш бус байдлын зарим илрэл байсаар байна. Хан үндэстэн болон Монгол үндэстний уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь тус тусын соёлын онцлогт чухал үүрэг гүйцэтгэжээ. Эдгээр уламжлалт жендэрийн үзэл баримтлал нь тухайн үндэстний орчин үеийн бэлгийн үзэл баримтлалд нөлөөлөөд зогсохгүй соёлын солилцоонд бас нөлөө үзүүлдэг. Эдгээр уламжлалт ойлголтууд болон тэдгээрийн хувьсал өөрчлөлтийг ойлгох нь өнөөгийн нийгэм дэх бэлгийн үзэл баримтлалыг ойлгоход чухал ач холбогдолтой юм.

Хятад соёл дахь “Нян Пао” -ийн дэлгэрэлт, нийгмийн хариу үйлдэл

Сүүлийн жилүүдэд Хятадад “Нян Пао соёл” (娘炮文化, sissy culture) сошиал медиагаар хурдацтай нэвтэрч, ялангуяа Япон, Солонгосын поп соёлын нөлөөгөөр, К-поп хөвгүүдийн хамтлагуудын нүүр будалт, биеэ авч явах хэв маяг нь Хятадын залуучуудад хүлээн зөвшөөрөгдөж, түгээмэл болж байна. Иймэрхүү байдал нь нийгмийн хүрээнд өргөн маргаан хэлэлцүүлгийг бий болгож, хүмүүсийн нэг хэсэг нь уламжлалт жендэрийн үүргийн хил хязгаарыг давж, соёлын хувьд жендэрийн тэгш байдал, олон талт байдлыг дэмжихэд тусалдаг гэж үздэг бол уламжлалт бэлгийн үзэл баримтлалтай хүмүүс нь “Нян Пао соёл”-ийг эрчүүдийн эрэгтэйлэг чанарыг сулруулж, нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үздэг; Орчин үеийн Хятадын Хан үндэстний нийгэмд “Нян Пао соёл”-ийн нөлөө маш их байгаа нь нийгмийн ширүүн маргаан болон ээдрээтэй хариу үйлдлийг үүсгэжээ. Үүний зэрэгцээ Өвөр Монголчуудын нийгэм нь энэхүү соёлын үзэгдэлд өөр байдлаар хандаж, өөр хариу үйлдэл үзүүлж ирсэн нь тэдний уламжлалт бэлгийн үзэл баримтлалтай нь холбоотой. Энэхүү хэсэг нь “Нян Пао соёл” Хятадад нэвтэрсэн үйл явцыг кейс шинжилгээгээр судалж, Хан болон Өвөр Монголчуудын нийгэмд үзүүлэх нөлөөллийг шинжлэн, энэ соёлын нөлөөний өдөөс авч хэрэгжүүлсэн өөр өөр арга хэмжээг авч үзэх болно.

“Нян Пао соёл” соёл Хятад улсад дэлгэрсэн үйл явц

Эрт дээр үед “Нян” (娘) гэдэг нь залуу эмэгтэй гэсэн утгатай байсан бөгөөд энэ нь эрэгтэй хүнийг оноосон нэрийдэл биш байв. Өнөөгийн нийгэмд хүнийг “Нян” (炮) гэж тодорхойлох нь эрэгтэй хүн эмэгтэйд шинж чанартай байхыг илэрхийлдэг болжээ. Энд “Пао” гэдгийг махчилж орчуулбал том буу гэсэн үг, эр бэлгийн эрхтнийг илэрхийлдэг. Тиймээс “Нян Пао” (娘炮) гэдэг үг нь “том буутай” эрэгтэй хүн эмэгтэйд шинжтэй байхыг илэрхийлж байна гэж шууд ойлгож болно. “Нян Пао” (Sissy) гэдэг нь эрэгтэйчүүдийн хувцаслалтын хэв маяг, гадаад төрх байдал, хэл ярианы илэрхийлэл, сонирхол нь эмэгтэйд шинж тэмдэгтэй байхыг тусгайлан илэрхийлдэг интернэтийн алдартай үг юм. Энэ нь царайлаг байх, үгүйтэй ямар ч хамаагүй, эрэгтэй хүнийг царайлаг гээд л “Нян Пао” гэж хэлдэггүй. энэ нь мөн ч доромжилсон өнгөтэй үгс юм. Бодит байдалд ихэнх хүмүүс “Нян Пао”-ийн талаар сөрөг хандлага, хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд үүний үр дүнд “Нян Пао”-ийг жигшин зэвүүцэх, үзэн ядах, гадуурхах, “эмэгтэйд эрэгтэйдгээс айх, жигших” (sissyphobia) байдал үүсдэг. 1980-аад онд Хятадад “цөцгий хөвгүүд” гэж хочилдог байсан царайлаг дүр төрх, эмэгтэйд гоо үзэсгэлэнтэй хэсэг эрэгтэй жүжигчид гарч ирэв. Тэр үеийн “цөцгий хөвгүүд”-ийн эсрэг хандах шүүмжлэх дуу хоолой нь одоогийн залуучуудаас хол илүү байсан. Хүмүүс яагаад ингэдэг гэдгээ тайлбарлахдаа Хятадын нийгэм эрт дээр үеэс эрэгтэйчүүдийн биеэ авч явах байдал, нийгэм, гэр бүлд хариуцах үүргийг маш их чухалд үздэг. Тодруулбал, Хятадын олонх хүмүүст эрэгтэйчүүд нь эр хүний омог сүртэй байж, улс гэрээ авч явах хүнд үүргийг хүлээсэн хатуу зоримог эр хүний дүр төрхтэй байх ёстой гэдэг хэвшмэл ойлголттой байдаг. Сүүлийн жилүүдэд, зарим кино, телевизийн жүжиг хүмүүсийн анхаарлыг татах эсвэл зарим хүмүүсийн гоо зүйн үзэмжид нийцүүлэхийн тулд зориудаар “Нян Пао” дүр төрхийг бий болгосон. Түүнчлэн, “Нян Пао соёл”-ын бий болсон шалтгааныг ярихад, эдийн засгийн хөгжил, эмэгтэй хүний гоо зүйн өөрчлөлт, “Нян Пао” оддын арилжааны үйл ажиллагаа, шинэ мэдээллийн хэрэгслийн хөгжил, ухаалаг гар утасны түгээмэл байдал зэрэг нийгмийн өвөрмөц онцлогтой холбон үзэж болно. Мөн Япон, Солонгосын соёлын нөлөөлөл “Нян Пао соёл”-ыг сурталчлах, хэрэглэх нь зах зээлийн үндсийг тавьсан. Гэсэн хэдий ч хэрэглэгчдийн “Нян Пао соёл”-ын хэрэглээ нь аяндаа биш, харин соёлын зах зээл, капиталжуулалтын үйл ажиллагааны үр дүн гэдгийг харж болно⁴ (刘潇蔓 2022).

“Нян Пао соёл”-ын нийгмийн нөлөө

“Нян Пао соёл” нь Хятадын залуучуудад жендэрийн танин мэдэхүй, илэрхийлэл, загвар ба гоо зүй, сэтгэцийн эрүүл мэнд, өөрийгөө таних байдал, нийгмийн үзэл бодол, дарамт, үйл ажиллагааны хэв маяг, үнэт зүйлс зэрэг салбарыг хамарсан олон талын нөлөө үзүүлсэн. Юуны өмнө, “Нян Пао соёл” нь уламжлалт жендэрийн үүрэг, хэм хэмжээг сорьж, залуучуудыг жендэрийн баримжаа, зан чанараа илүү чөлөөтэй илэрхийлэхийг дэмжиж, зарим залуучуудыг жендэрийн илэрхийллийн олон хэлбэрийг илүү хүлээн зөвшөөрдөг болгосон байдаг. Хоёрдугаарт, “Нян Пао соёл”-ын нөлөөгөөр Солонгос, Японы поп дуу бүжгийн хөгжмийн хамтлагийн залуучууд хээнцэр сайхан нүүр будалт хувцаслалтаар хүмүүсийн өмнө ялгардаг болсноор иймэрхүү гоо зүйн үзэл баримтлал нь Хятадын энгийн залуучуудын дунд бас урсгал болжээ. Сэтгэцийн эрүүл мэнд, өөрийгөө таних тал дээр “Нян Пао соёл”-ыг түгээн дэлгэрүүлэх нь уламжлалт жендэрийн хүлээлтэд үл нийцэх залуучуудад өөрийн гэсэн танин мэдрэхүй, харьяаллыг олох талбарыг тодорхой хэмжээгээр олгож байна. Гэсэн хэдий ч энэ соёл нь зарим залуучуудыг ялангуяа нийгэм, гэр бүлээс жендэрийн уламжлалт хүлээлттэй зөрчилдөх үед төөрөлдүүлж, дарамтад оруулах нь бий. Нэмж дурдахад “Нян Пао соёл” нь залуучуудын дунд түгээмэл тархсан ч өнөөгийн нийгэмд маш их маргаан, шүүмжлэл дагуулж байна. Зарим хүмүүс энэ соёл нь уламжлалт жендэрийн хэм хэмжээг алдагдуулж, өсвөр үеийнхний өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг. Тиймээс зарим залуучууд энэ соёлыг дагаж мөрдөхдөө нийгэм, сургууль, гэр бүлийн шүүмжлэл, дарамт шахалттай тулгардаг.

Өвөр Монголын монголчуудын дунд “Нян Пао соёл”-ын нөлөө харьцангуй бага байгаагийн гол шалтгаан нь Монголчуудын уламжлалт соёл, нийгмийн бүтэц нь жендэрийн үүргийн хүлээлт, хэм хэмжээ харьцангуй тодорхой байдагтай холбоотой. Өвөр Монголын монголчууд бэлгийн үзэл баримтлал нь харьцангуй нээлттэй, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байр суурь харьцангуй тэгш байдаг ч гэсэн нүүдэл амьдралын хэв маяг нь эрт дээр үеэс эрэгтэйчүүд байгалийн хатуу ширүүн орчин, дайн тулаантай холбоотой нийгмийн салбарт илүү их хөдөлмөр эрхэлдэг болохыг тогтоожээ. Иймээс Монголчуудын нийгэмд эрэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг хүчтэй, зоригтой байхыг шаарддаг бөгөөд эмэгтэйчүүдийн эрэгтэй хүнээс хараат байх байдал, хань сонгох чиг баримжаа ч үүнээр дамжиж бүрэлдэж байна. Иймэрхүү нийгмийн бүтэц, соёлын онцлогоос шалтгаалж Өвөр Монголчуудын нийгэм “Нян Пао соёл” буюу туранхай, цайвар царайтай, эмэгтэйд дүр төрхтэй эрэгтэйчүүдийг төдийлөн хүлээн зөвшөөрдөггүй.

⁴ Агуулгын энэ хэсэг нь Хятадын хамгийн том хайлтын систем болох Байдугийн (百度 Baidu) тайлбар юм. Байдугийн энэ агуулгыг “Нян Пао соёл” үүссэн түүхэн шалтгаан гэж иш татав.

Гэхдээ энэ соёл нь Өвөр Монголд огт орж ирээгүй гэсэн үг биш. Харин Өвөр Монголчуудын хувцаслалт, үс засалтын загварт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Тухайлбал, зарим залуус солонгос хувцаслалтын хэв маяг, үс гэзэгний хэв маягийг дуурайж эхэлсэн ч энэ нөлөө нь гадаад байдлын түвшинд л ажиглагдаж байна.

Хан үндэстэн болон Өвөр Монголчуудын ийм ялгаа нь түүх, соёлын гарал үүсэлтэй нь нягт холбоотой. Хан үндэстэн голчлон газар тариалангийн соёлтой байдаг бол Монголчууд нүүдлийн мал аж ахуйн соёл иргэншилтэй бөгөөд энэ хоёр амьдралын хэв маяг нь тэдний жендэрийн үүрэг, соёлын үзэл баримтлалд ихээхэн нөлөөлсөн байна. Газар тариалангийн соёлтой Хятадын Хан үндэстний нийгэм нь тогтвортой байдал, удаан даамгай байдлыг чухалчилдаг бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваагдал нь харьцангуй тодорхой боловч оршин тогтнохын төлөөх дайн байлдаан хийх нь бага байдаг. Газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан Хан үндэстний нийгэм нь эрэгтэйчүүдэд тавигдах шаардлага харьцангуй бага, жендэрийн үүрэгт илүү уян хатан байдаг. Түүнчлэн Хан үндэстний соёл нь түүхэн цаг хугацааны туршид харийн соёлын нөлөөнд ялангуяа орчин үед барууны болон хөрш зэргэлдээ орнуудын (Япон, Өмнөд Солонгос гэх мэт) соёлын нөлөөнд ихээхэн өртөж, бэлгийн үзэл баримтлал нь илүү олон янз болсон. Үүний эсрэгээр нүүдлийн соёл иргэншилтэй Өвөр Монголчуудын нийгэм байгалийн гамшиг, дайн тулааныг даван туулах шаардлагатай байдаг тул эрчүүд гэр бүл, мал сүргээ хамгаалах үүрэг хариуцлага хүлээж хүчирхэг бие махбод, эр зоригтой байх ёстой гэдэг шаардлагыг хүлээдэг. Тиймээс Өвөр Монголчуудын нийгэмд эрэгтэйчүүдээс маш их зүйл хүлээж байдаг бөгөөд уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь Өвөр Монголчуудын соёлд гүн гүнзгий шингэсэн байдаг. Өвөр Монголчууд уламжлалт соёлоо хадгалан үлдэх нь тэдний жендэрийн үзэл баримтлалд нөлөөлөх чухал хүчин зүйл юм. Орчин үежилт, даяаршлын үеийн харийн соёлын нөлөө их байсан ч Өвөр Монголчууд уламжлалт зан заншил, үнэт зүйлээ хамгаалж хадгалахыг зорьдог. Эдгээр уламжлал нь өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэхээс гадна Өвөр Монголчуудын соёлын өвөрмөц байдал, нийгмийн хэм хэмжээнд чухал байр суурийг эзэлжээ. Тухайлбал, “Эрийн гурван наадам” нь Монголчуудын уламжлалт спорт төдийгүй эрчүүдийн эршүүд байдал, эр зориг, хүч чадлын бэлгэдэл юм. Энэ нь Өвөр Монголчуудын баяр ёслол, зан үйлд чухал байр суурь эзэлдэг төдийгүй эмэгтэйчүүдийн хань сонгох болон Монголчуудын жендэрийн үзэл баримтлалын талд гүн гүнзгий нөлөө үзүүлжээ.

“Нян Пао соёл”-ын нөлөөллийн эсрэг хоёр талын дуу хоолой байгаа нь анхаарагдсан. Нэг нь, “Нян Пао” гэдэг үгийг эмэгтэй хүнийг хүндэлдэггүй,

ялгаварлан гадуурхсан үг гэж үздэг. 2017 оны 7-р сард “China Women’s News” сэтгүүлд хүйсээр ялгаварлан гадуурхах хориотой үгсийг нийтэлсэн бөгөөд “Нян Пао” нь жагсаалтад багтжээ. Түүнчлэн “Нян Пао” гэсэн нэр томьёо нь эрчүүдийг үл хүндэтгэж, тэдний олон янз байдлыг үгүйсгэдэг гэсэн үзэл бодол байдаг. Энэ нэр томьёо нь хүйсийн хэвшмэл ойлголтын тусгал бөгөөд эрэгтэй хүний шинж чанарын олон янз байдлыг үгүйсгээд зогсохгүй эмэгтэйлэг байдал, эмэгтэйлэг гоо сайхныг дорд үзсэн бөгөөд энэ нь нийгмийн гоо зүйн олон янз байдлын ерөнхий чиг хандлагатай нийцэхгүй байна. Эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нь ч өөрийн гэсэн өвөрмөц зан чанартай байж болох бөгөөд уламжлалт жендэрийн хэм хэмжээнд нийцэхгүй байна гэж дайрч болохгүй гэжээ. Гэсэн хэдий ч 2021 оны есдүгээр сард Төрийн Радио Телевизийн Ерөнхий газраас “Утга зохиол, урлагийн нэвтрүүлэг, түүний боловсон хүчний менежментийг цаашид бэхжүүлэх тухай” мэдэгдэл гаргаж, “Нян Пао”-ийг “хэвийн бус гоо зүй” гэж, хойшдоо “иймэрхүү байдлыг сурталчилсан, Айдол (idol) шалгаруулах тэмцээн, “Нян Пао” залуусын байгуулах, бүжгийн хөдөлгөөнд “эмэгтэйлэг элемент” нэмэх, программ, кино байхыг хориглоно” гэж тогтоожээ. Түүнчлэн, “Нян Пао соёл”-ын маргааны ард бага насны хүүхдүүдэд жендэрийн ойлголтыг бий болгох тухай асуулт байдаг гэж хүмүүс гэр бүлийн боловсролын хүрээнээс авч үзжээ. Жендэр судлалын мэргэжилтнүүд хүүхдүүд 3 наснаас эхлэн жендэрийн талаарх ойлголттой болсон гэж үздэг. Хүүхдэд багаас нь жендэрийн боловсрол олгох нь эрүүл эр хүнийг төлөвшүүлэх эхний алхам юм. Өнөөгийн нийгэмд эцэг эхчүүд амьдрахын тулд асар их дарамттай тулгарч, гэр бүлээ тэжээхийн тулд гэрээсээ гарч ажил хийх шаардлагатай болдог, тэгээд хүүхдүүдийг эмээ, ээж, эмэгтэй асрагч гэх мэт эмэгтэй дүрүүд асран тэжээж, аав, өвөө мэтийн эрэгтэй дүр оролцох нь ховор болох тул хүүхдүүдийн зан чанар, зан байдал нь “эмэгтэйлэг” байх хандлагатай байдаг. Эцэг эхчүүд хөвгүүдэд багаас нь эрүүл саруул хөвгүүдийн зан чанарын онцлогийг ойлгуулж, охид, хөвгүүдийн хоббигийн ижил төстэй болон ялгаатай талуудыг ойлгуулж, охид, хөвгүүдийн хоорондын хүндэтгэл, хамтын ажиллагаанд суралцах хэрэгтэй. Энэ төрлийн боловсрол нь эцэг эхчүүдээс үүнийг тусгайлан зааж өгөхийг шаарддаггүй, харин эцэг эхээс өдөр тутмын амьдралдаа хүүхдийнхээ жендэрт тохирсон зан үйлийг магтаж, зан чанар, зан төлөвийн хувьд жендэрийн дүрд идэвхтэй үлгэр дуурайл үзүүлэхийг шаарддаг.

Дүгнэлт

Бэлгийн үзэл баримтлалын бүрэлдэл, хувьсал нь олон соёлын элементийн нөлөөг хүртэж байдаг. Эдгээр үзэл баримтлал нь хувь хүний бэлгийн танин

мэдрэхүй, үйл ажиллагаанд нөлөөлөхөөр барахгүй бас нийгмийн бүтэц, соёлын уламжлалд нөлөөлдөг. Тиймээс онцгойлон одоо цаг үеийн нөхцөл байдалд соёл хэрхэн бэлгийн үзэл баримтлалыг нөлөөлж байхыг ойлгох нь маш чухал юм. Ийм учраас би энэхүү өгүүлэлдээ дараах санааг дэвшүүлсэн: Хятадын уламжлалт бэлгийн үзэл баримтлал нь Күнзийн үзэл баримтлалд тулгуурлан жендэрийн үүргийн ялгаа, тэгш бус байдлыг онцолсон байдаг. Эдгээр ойлголтууд нь Хан үндэстний одоогийн бэлгийн үзэл баримтлалд гүн гүнзгий суурилжээ. Үүний эсрэгээр Өвөр Монголчуудын бэлгийн үзэл баримтлал нь эрт дээр үеэс харьцангуй тэгш байсан ч уламжлалт ёс заншил, хорио цээрт нь бэлгийн үзэл баримтлал нь жендэрийн тэгш бус байдлыг илэрхийлдэг. Үүнээс гадна, Хятадад дэлгэрсэн энэ соёлын үзэгдэл нь уламжлалт бэлгийн үзэл баримтлалд даяаршлын үеийн харь соёлын үзүүлсэн “будилаантай” нөлөөний илрэл болно. Хэдийгээр энэ нь жендэрийн олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдлыг дэвшүүлсэн ч бас олон маргаан хэлэлцээний үндэс болсон. Хан үндэстний нийгэмтэй харьцуулбал Өвөр Монголчуудын нийгэмд төдий их нөлөөлөл орсонгүй ч жендэрийн үүрэг, бэлгийн үзэл баримтлал, соёлын уламжлалын талд бодлогошрол авчрах нь зүй ёсны хэрэг юм. Цаашдын судалгаанууд нь дараах асуудлуудад анхаарлаа хандуулж болно. *Нэгдүгээрт*, соёл хоорондын харьцуулалт хийж, бусад үндэстний цөөнхийн бэлгийн үзэл баримтлал, өөрчлөлтийг гүнзгийрүүлэн судалж, Хан үндэстний болон Хан үндэстний бэлгийн үзэл баримтлалтай илүү өргөн хүрээтэй харьцуулсан дүн шинжилгээ хийх шаардлагатай. *Хоёрдугаарт*, модернизацийн үйл явц, даяаршлын уламжлалт бэлгийн үзэл баримтлалд үзүүлэх нөлөө, ялангуяа бэлгийн үзэл баримтлалыг түгээхэд шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түгээмэл соёлын гүйцэтгэх үүргийг судлах нь маш чухал юм. *Гуравдугаарт*, жендэрийн үзэл баримтлалыг өөрчлөхөд төрийн бодлого, боловсролын тогтолцооны үүрэг оролцоонд дүн шинжилгээ хийж, бодлого, боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангах талаар судлах. Эцэст нь, илүү тодорхой кэйсэд дүн шинжилгээ хийснээр бэлгийн үзэл баримтлалын хувь хүний амьдрал дахь тодорхой илрэл, нөлөөллийг илрүүлж, жендэрийн тэгш байдлын бодлогын талаар илүү бодитой лавлагаа болно. Товчхондоо, бэлгийн уламжлалт үзэл баримтлал, түүний орчин үеийн хувьслын талаар гүнзгийрүүлэн судалснаар бид жендэрийн асуудлыг илүү сайн ойлгож, шийдвэрлэж, илүү тэгш, хүртээмжтэй (单击或点击此处输入文字) нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулж чадна.

Abstract

Sexual attitude under the influence of national culture: Comparing Han chinese and Inner Mongolians

Tonggalaga

This article aims to clarify the differences in sexual attitudes within cultural contexts by comparing the influence of traditional culture on sexual attitudes using the examples of the Han Chinese and Inner Mongolians in China. Researchers in China have an extensive history of studying the sexual attitude of the Han nationality, ranging from textual research to social science research. However, in this study, there is very little research on the sexual attitudes of Inner Mongolians, and to be specific, there have only been attempts to indirectly examine these attitudes through the study of literary characters. In this study, hypothesized that “traditional culture” not only influences sexual attitudes but also that over time, traditional sexual attitudes intertwine with contemporary attitudes and even influence the sexual attitudes of other cultures. To achieve this, we analyzed previous studies, source documents, specific examples of sexual attitudes among Han Chinese and Inner Mongolians, and real-life cases.

Keywords: National cultural influence, Sexual attitude, Han Chinese, Inner Mongolians

Ном зүй

Baasanjav Terbish (2013). Mongolian Sexuality: A Short History of the Flirtation. Inner Asia, 243-271.

Гэрэл (2017). Овоон тахилга дэх эмэгтэй хүнд холбогдох цээр ёс. Улаанахадын дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл: 13-17.

于光君. (2016). 儒家的人本主义性别观. 中华女子学院学报, 97-102.

刘潇蔓. (2022). 消费文化语境下“娘炮”现象成因分析. 传媒论坛: 69-71.

叶文静. (2011). 论儒家的性别观. 社会研究: 96-97.

弗洛伊德. (2015). 图腾与禁忌. 北京: 中央编译出版社.

方旭东. (2020). 儒道思想与现代社会. 北京: 中华书局有限公司.

陈高华. (2018). 元代妇女史. 背景: 中国社会科学出版社.

顾辉. (2013). 国家、市场与传统社会性别观念回潮. 学术界: 104-114.

Received: Oct. 6, 2024; Revised: Nov. 10, 2024; Accepted: Dec. 16, 2024

